



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 8/61

Хэрлэн сум

Мөнгөн шагналаар шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.15, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар өөрчлөлтгүй дүгнэлттэй гарч, албан тушаалын чиг үүргээ амжилттай биелүүлэн, өр авлагагүй ажилласан тул Нягтлан бодогч Энхбаатарын Ариунтунгалагийг 1,5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн шагналаар шагнасугай.

2. Шагналын зардалд зарцуулах 1,292,235 (нэг сая хоёр зуун ерөн хоёр мянга хоёр зуун гучин тав) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын цалингийн зардлаас гаргахыг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР